



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ТӨВ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ТӨСВИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

ТАБ-ын Дарга, тэргүүлэх аудитор

Л.Жаргалсайхан

И-мэйл: jargalsaihan_tuv@yahoo.com

Утас: 70272582

Факс: 01-272-22582

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Утас: 70273465

Шинжээч

А.Батлхавага

Утас: 70273463 96011185

И-Мэйл: abatlhagva@yahoo.com

Аймгийн аудитын газрын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

Цахим хуудас: www.audit.mn

2016 оны 2 дугаар сар 25

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Цагдаагийн газрын төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ТӨВ-2016/28/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Цагдаагийн газрын төсвийн 2015 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай болон нийцлийн аудит 4200-р стандарттай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Цагдаагийн газрын 2015 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 01 дүгээр сарын 25-наас 2016 оны 02 дүгээр сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн шинжээч А.Батлхавга хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Цагдаагийн газар нь 2015 оны төсвийн санхүүгийн тайланг 2016 оны 01 дугаар сарын 25-нд ТАБ-т ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2016 оны 01 дүгээр сарын 25-наас 2016 оны 02 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2016 оны 02 дугаар сарын 25-нд Төв аймгийн Цагдаагийн газрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Монгол улсын үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Цагдаагийн албаны тухай хуулийн 13-р зүйлийн 13.1-д “Цагдаагийн төв байгууллага нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан нийтлэг асуудал

эрхэлж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг улсын хэмжээгээр нэгтгэн зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах харилцан уялдаа бүхий цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу тухайн байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Цагдаагийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйл Гэмт хэрэгтэй тэмцэх, 10 дугаар зүйл.Нийтийн хэв журам хамгаалах, 11 дүгээр зүйл. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах гэж зорилго зорилтоо тодорхойлсон байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “агентлагын дарга тус агентлагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Төв аймгийн Цагдаагийн газар байгууллагын дарга төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна

Төсвийн шууд захирагчийн төсвийг ЦЕГ-аас баталж Төв аймгийн төрийн сангаас олгож байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, үйл ажиллагаатай холбогдсон хуулиуд бүрэн хэрэгжсэн байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Цагдаагийн газрын төсвийн 2015 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс Цагдаагийн газрын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын 11 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ЦЕГ-аас боловсруулан мөрдөн ажиллаж байна.

ЦЕГазрын даргын 2013.06.27-ний өдрийн 422 тоот тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг мөрдөж байна. Энэ хү баримт бичигт Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Сангийн сайдын 2013.12.02-ний өдрийн 269-р тушаалаар нягтлан бодох бүртгэлийн дансны зааварт орсон өөрчлөлт, түүнийг мөрдөх аргачлал, ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Үндсэн хөрөнгөд элэгдэл тооцох тухай” журмыг 2014 оны 297 дугаар тогтоолоор хүчингүй болгосон зэргийг тусгаж шинэчлэгдээгүй байна. Бүртгэлийн асcolous програм ашигладаг байна.

Төсвийн шууд захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг

хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төв аймгийн ЦЕГазрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж хянахад Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн программаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу ЦЕГазрын Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2015 онд улсын төсвөөс урсгал болон хөрөнгийн зардалд 2515948.4 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар 10588.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан. Мөн төсөвт байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогоор нийт 24868.5 мянган төгрөг төвлөрүүлэн мөнгөн гүйлгээний тайлангаар 2551405.1 мянган төгрөгийг зарцуулсан. Мөнгөн гүйлгээний тайланд зарцуулаагүй үлдэгдэл 26239.2 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлж, төвлөрүүлэх шилжүүлэгээр тайлагнасан байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2015 оноос "shilendans.gov.mn" цахим сайтад зохих мэдээллийг оруулсан. Тус байгууллагын шилэн дансны мэдээллийг завсарын аудитаар эхний 8 сарын байдлаар шалгахад журмын дагуу мэдээллийг оруулсан. Харин Шилэн дансны тухай хуулийн 5.7-д "Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна" гэж заасны хэрэгжилтийг шалгаж хэрэгжилтийг гаргуулсан байна.

2016 оны 1-р сараас эхлэн цахим сайт өөрчлөлт сайжруулалт хийгдэж өмнөх мэдээллээ устгаж, дахин оруулсан гэсэн боловч шинэ сайтад нэвтэрч чадаагүй болно.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 9 данс 30 уламжлалт эрсдэлийг, 6 данс 8 хяналтын эрсдэлийг тогтоож, Гүйцэтгэлийн үе шатанд 11 горим, нарийвчилсан сорилыг хийж гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төв аймгийн ЦЕГазрын төсвийн 2015 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Албан томилолтыг зардлыг удирдлагаар баталгаажуулаагүй өөртөө томилолт олгон ажилласан 144.0 мянган төгрөгийн албан томилолт олгосон байна. Энэ нь ЗГазрын 1995 оны 218-р тогтоолын 3.12 заалт "Албан томилолтын зардлын тооцоог ирснээсээ хойш ажлын 5 өдөрт багтаан гүйцэтгэсэн ажлынхаа үр дүнг албан томилолт олгосон удирдах албан тушаалтанд танилцуулан томилолтын үнэмлэх дээрээ гарын үсэг зуруулна

Шийдвэрлэсэн: Албан томилолтын удирдамж гүйцэтгэлийг удирдлагаар баталгаажуулан олгож байх талаар зөвлөмж өгөв.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад 144.0 мянган төгрөгийн материаллаг алдаа илэрсэн. Материаллаг бус алдаа зөрчил илрээгүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацаанаас шалтгаалан аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй туслах аж ахуйн болон үнэт цаасны тооцоог завсрын аудитаар нөхөн шалгахаар тогтоов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Цагдаагийн газрын урсгал төсвийн 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг хэмжээний 144.0 мянган төгрөгийн алдаа илэрсэн ба материаллаг бус алдаа зөрчил илрээгүй байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Цагдаагийн газрын 2014 оны санхүүгийн тайланд Төв аймгийн Аудитын газраас хийсэн аудитаар 2 зөвлөмж өгсөн бөгөөд бүрэн хэрэгжсэн байна.

Зөрчилгүй санал дүгнэлт:

Төв аймгийн Цагдаагийн Газрын төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: ШИНЖЭЭЧ



Л.ЖАРГАЛСАЙХАН

О.АМАРЖАРГАЛ

А.БАТЛХАВГА

2016 оны 02 сарын 24

ТӨВ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН



2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс

Асуудал 1

НББ-ийн талаар

3

Менежментийн захидал

Төв аймгийн аудитын газар нь аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Төсвийн захирагчийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

АГ-ын ажиглалт

Албан томилолтын зардлыг удирдах албан тушаалтнаар баталгаажуулаагүй олгосон.

АГ-ын зөвлөмжүүд

УСНББОУС, Сангийн сайдын 2006 оны 388, 2015 оны 06дугаар сарын 19ний Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, журмыг дагаж мөрдөх

Эрсдэлүүд

ЗГазрын 1995 оны 218-р тогтоолын 3.12 заалт "Албан томилолтын зардлын тооцоог ирснээсээ хойш ажлын 5 өдөрт багтаан гүйцэтгэсэн ажлынхаа үр дүнг албан томилолт олгосон удирдах албан тушаалтанд танилцуулан томилолтын үнэмлэх дээрээ гарын үсэг зуруулна

Үйлчлүүлэгчийн хариу

2016 оны 4 дугаар сарын 01-ний дотор зөвлөмжийг биелүүлэх талаар арга хэмжээ авч ажиллана.



МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Л.Жаргалсайхан

АУДИТЫН МЕНЕЖЕР:

О.Амаржаргал

БЭЛТГЭСЭН:

ШИНЖЭЭЧ:

А.БАТЛХАГВА

